

## Оюутны сургалтын төлбөрийн эх үүсвэрийг тогтоосон судалгааны тайлан

**Зорилго:** Оюутны сургалтын төлбөрийн эх үүсвэрт байгалийн нөөцийн ашиглалт хэрхэн ноогдож байгааг тогтоох


**Судалгаанд оролцогчид:** Судалгааг МУБИС-ын 10 оюутан хамтарч хийсэн. Үүнд: Н.Ганхуяг, ГЗБ-III; С.Баярмаа, ГЗБШ-II; Г.Мөнхбат, ГЗБ-I; Бат-Эрдэнэ, МСТ-II; Цэнд, Англи хэл-II; М.Батчимэг, ББШ-III; М.Насанжаргал, ГЗБУ-I; Г.Баянмөнх, ХБШ-II; Т.Мөнхзул, ТНУС-III; С.Наранчимэг, Мат-II

**Тайлан боловсруулсан:** МУБИС-ын докторант Б.Мөнхчулуун

**Хугацаа:** 2007.09.17 – 25 хүртэл судалгааг зохион байгуулсан.

**Хамрах хүрээ:** Судалгаанд 21 аймгийн 217 сумын харьяалалтай МУБИС, 1-4-р курсын 1000 оюутан хамрагдсан. Энэ нь МУБИС –ийн нийт оюутны 16.13%-г эзэлж байна.

**Харьяалалын хувьд:** Баян-Өлгий аймгаас 52, Ховд аймгаас 35, Увс аймгаас 54, Завхан аймгаас 63, Говь-Алтай аймгаас 48, Баянхонгор аймгаас 63, Архангай аймгаас 61, Өвөрхангай аймгаас 59, Хөвсгөл аймгаас 62, Сэлэнгэ аймгаас 49, Булган аймгаас 39, Дархан-Уул аймгаас 25, Орхон аймгаас 28, Төв аймгаас 55, Өмнөговь аймгаас 29, Дорноговь аймгаас 44, Говь-Сүмбэр аймгаас 11, Сүхбаатар аймгаас 66, Хэнтий аймгаас 67, Дорнод аймгаас 50 оюутан судалгаанд хамрагдсан байна. Судалгаа хийхдээ хөдөө орон нутгаас суралцаж байгаа оюутнуудыг хамруулахыг зорьсон. Судалгааны дүнгээс харахад 21 аймгаас жигд хамрагдсан нь харагдаж байна (Диаграмм-1).



**Диаграмм-1. Судалгаанд хамрагдсан оюутны харьяалал**

**Арга зүй:** Судалгааг 2 арга зүйгээр явуулсан. Үүнд:


1. *20-хүртэлх оюутнуудад тайлбарлан ярьж хүснэгт бөглүүлэх.* Энэ арга нь цаг хугацааг хэмнэж байсан боловч судалгаа хийж буй хүн бүх оюутнуудтай харьцаж чадахгүй байсан учраас зарим нь сайн ойлгоогүйгээс дутуу, буруу бөглөх үе гарч байсан. Ийм үед судалгааны анкетуудыг хянаж үзээд алдаатай, буруу, дутуу бөглөснийг нь хасаж явсан.
2. *Ганцаарчилан болон цөөн тооны оюутнуудтай ярилцлага хийх.* Энэ арга нь төлбөрийн эх үүсвэрийг үндэслэлтэй гаргахад илүү тохиромжтой байсан ба цаг хугацаа их шаардаж байсан. Эцсийн үр дүнг үндэслэлтэй гаргахын тулд судалгааны 80%-д энэ аргыг ашигласан.

**Судалгааны үр дүн:** Судалгаанд оролцсон оюутны төлбөр нь нийт 13 төрлийн эх үүсвэрээс бүрдэж байна. Үүнд: Мал аж ахуй, хувийн бизнес, цалин, өөрөө ажил эрхлэх, төрийн сангийн зээл, компаний гэрээ, буцалтгүй тусламж, тэтгэвэр, ан амьтан, жимс, мод, газар тариалан, гадаадад ажиллаж байгаа ах дүү нарын цалин зэргээс бүрдэж байна. Ойролцоогоор нэг оюутны төлбөр нь дээрх жагсаалтад хамрагдах 1-4 эх үүсвэртэй байна.

Сургалтын төлбөрийн эх үүсвэрийг нэгтгэж үзэхэд **1.Мал аж ахуй, 2. Цалин, төрийн зээл, 3.Байгалийн нөөц ашиглалт гэсэн үндсэн 3 бүлэг харагдаж байна.**

Судалгаанд хамрагдсан 1000 оюутны төлбөрийн эх үүсвэрийн 45.9% нь мал аж ахуй, 45,6% нь цалин, төрийн зээл(цалин, төрийн зээл гэдгийг дараагийн сэдэвт задалж үзүүлсэн байгаа), 8,5% нь байгалийн нөөцөөс бүрдүүлж байна.

**А. Сургалтын төлбөрийн эх үүсвэрийн 45.9%-ийг мал аж ахуйгаас бүрдүүлдэг байна.** Үүнээс 51.4% нь малаа зарах, 27.5% ноос ноолуур, 5.2% нь сүү цагаан идээ, 5.7% нь арьс шир, 10.2% нь малыг махалж зардаг байна (диаграмм -2).



**Диаграмм -2. Төлбөрийн мал аж ахуйгаас бүрдүүлдэг хувь**

Дүнгээс харахад мал аж ахуйгаас олох орлогын дийлэнх хэсэг буюу 51.4%-г шууд малаа зарах замаар олдог байна.

**Б. Цалин, төрийн зээл гэсэн бүлэгт:** Хувийн бизнес, эцэг эхийн цалин, өөрөө хөдөлмөр эрхэлдэг(байгалийн нөөц ашиглахаас бусад), төрийн сангийн зээл, компаний гэрээ, буцалтгүй

тусламж, тэтгэвэр, гадаадад байдаг ах дүүгийн цалин гэсэн хувилбарууд багтаж байна. Эдгээр хувилбаруудын оюутны төлбөрийг бүрдүүлж байгаа хувийг хүснэгт 1-т үзүүлэв.

**Хүснэгт-1.**

**Төлбөрийг бүрдүүлж байгаа цалин, төрийн зээл бүлэгт хамаарах эх үүсвэрүүдийн эзлэх хувь**

| Хувилбарууд                         | Хувийн бизнес | Цалин | Өөрөө хөдөлмөр эрхэлдэг | Төрийн сангийн зээл | Компаний гэрээ | Буцалтгүй тусламж | Тэтгэвэр | Гадаадад буй ах дүү | Дотоодод ах дүү | Бүгд        |
|-------------------------------------|---------------|-------|-------------------------|---------------------|----------------|-------------------|----------|---------------------|-----------------|-------------|
| Нийт эх үүсвэрээс эзлэх хувь        | 14.9          | 15.3  | 1.5                     | 6.6                 | 0.5            | 0.9               | 3.3      | 1.3                 | 1.3             | <b>45,6</b> |
| Цалин төрийн зээл хэсэгт эзлэх хувь | 32.7          | 33.5  | 3.3                     | 14.4                | 1.1            | 2                 | 7.2      | 2.9                 | 2.9             | <b>100</b>  |

Дүнгээс харахад эцэг эхийн цалингаар сургалтын төлбөрийн эх үүсвэрээ бүрдүүлэх хувилбар илүү өндөр байгаа ба тодорхой нэг компаний гэрээгээр сурч төлбөрийн эх үүсвэрийг бүрдүүлэх хувилбар харьцангуй бага байгаа нь харагдаж байна.


**В. Судалгаанд хамрагдсан оюутнуудын сургалтын төлбөрийн 8.5% нь байгалийн нөөц ашиглаж бүрдүүлдэг. Үүний 51.7% нь ангийн нөөц, 32% нь ургамлын нөөц, 16.3% нь ашигт малтмалын нөөц ашиглаж сургалтын төлбөрөө бүрдүүлдэг байна (Хүснэгт-2).**

**Хүснэгт-2**

**Байгалийн нөөц ашиглалт бүлэгт хамаарах хувилбаруудын эзлэх хувь**

| Хувилбарууд                               | Ангийн нөөц | Ургамлын нөөц | Ашигт малтмал | Бүгд       |
|---|-------------|---------------|---------------|------------|
| Нийт эх үүсвэрээс эзлэх хувь              | 4.4         | 2.72          | 1.38          | <b>8.5</b> |
| Байгалийн нөөц ашиглалт хэсэгт эзлэх хувь | 51.7        | 32            | 16.3          | <b>100</b> |

Судалгааны дүнгээс харахад байгалийн нөөц ашиглалтын дотор 51.7% буюу ихэнх хувийг нь **ангийн нөөц** ашиглаж сургалтын төлбөрийн эх үүсвэрээ бүрдүүлдэг гэсэн хувилбар эзэлж байна. Үүнийг нарийвчлан задалж үзвэл чоно, тарвага, загас, үнэг, хярс, шонхор, цагаан зээр зэрэг амьтдыг ашиглаж төлбөрийн эх үүсвэрийн тодорхой хувийг бүрдүүлэх хувь нь бусад ангийн нөөцийн хувилбаруудас илүү байна. Диаграмм 3-аас харна уу.



**Диаграмм-3. Төлбөрийг бүрдүүлж байгаа ангийн нөөцийн эзлэх хувь**

Ангийн нөөц ашиглалтыг аймгаар нь харьцуулж үзэхэд Баян-Өлгий аймаг шонхор шувуу, загас, Хөвсгөл аймаг загас, тарвага, Булган аймаг загас, чоно, тарвага, Говь-Сүмбэр аймаг чоно, Сүхбаатар аймаг тарвага, цагаан зээр, Дорнод аймаг тарвага, чоно зэрэг ангийн нөөцийг ашиглаж сургалтын төлбөрийн эх үүсвэр болгох хувь нь илүү өндөр байна (Хүснэгт-3).

**Хүснэгт-3**

**Ангийн нөөцийг ашиглаж төлбөр бүрдүүлж байгаа оюутнуудын харъяалал (аймгаар)**


| Аймаг  | Баян-Өлгий | Ховд | Увс | Завхан | Говь-Алтай | Баянхонгор | Архангай | Өвөрхангай | Хөвсгөл | Сэлэнгэ | Булган | Дархан-Уул | Орхон | Төв | Өмнөговь | Дорноговь | Дундговь | ГовьСүмбэр | Сүхбаатар | Хэнтий | Дорнод | Бүгд |
|--|------------|------|-----|--------|------------|------------|----------|------------|---------|---------|--------|------------|-------|-----|----------|-----------|----------|------------|-----------|--------|--------|------|
| Тухайн аймгийнхаа нийт эх үүсвэрээс эзлэх хувь | 12,0       | 3,1  | 0,8 | 3,0    | 1,5        | 1,1        | 1,6      | 1,6        | 7,4     | 2,7     | 11,2   | 1,6        | 1,8   | 2,4 | 0        | 2,0       | 0        | 11,8       | 9,6       | 5,5    | 11,9   |      |
| Нийт ангийн нөөц ашиглалтаас эзлэх хувь        | 13         | 3,3  | 0,9 | 3,2    | 1,6        | 1,2        | 1,7      | 1,7        | 8       | 2,9     | 12     | 1,7        | 1,9   | 2,6 | 0        | 2,2       | 0        | 13         | 10        | 5,9    | 13     | 100  |

Судалгаанд хамрагдсан оюутнуудын хувьд ан амьтан ашиглаж сургалтын зардалын эх үүсвэр болгохдоо нийт зардалынхаа 5-100% хүртэл бүрдүүлж байна (Хүснэгт-4). Нийт судалгаанд оролцсон оюутнуудын **13.5%** буюу 135 нь сургалтын зардалынхаа эх үүсвэрийн тодорхой хувийг ан амьтны нөөцөөр бүрдүүлдэг байна. Үүнд: Сургалтын нийт зардалынхаа 10-30%-г ан амьтны нөөцийг ашиглан бүрдүүлдэг оюутнууд ихэнх хувийг эзэлж байна (Хүснэгт-4).

## Сургалтын төлбөр бүрдүүлэхэд оролцож байгаа ангийн нөөц ашиглалтын хувь

|                                     |      |      |      |      |       |       |      |       |       |      |       |      |        |
|-------------------------------------|------|------|------|------|-------|-------|------|-------|-------|------|-------|------|--------|
| Оюутны нийт эх үүсвэрээс эзлэх хувь | 100  | 70   | 65   | 60   | 50    | 40    | 35   | 30    | 20    | 15   | 10    | 5    | Бүгд   |
| Оюутны тоо                          | 1    | 2    | 1    | 7    | 16    | 19    | 3    | 29    | 22    | 2    | 28    | 5    | 135    |
| Энэ хэсэгт эзлэх хувь               | 0.74 | 1.48 | 0.74 | 5.19 | 11.85 | 14.07 | 2.22 | 21.48 | 16.29 | 1.48 | 20.74 | 3.72 | 100.00 |

**Ургамлын нөөц** ашиглалтын хувьд судалгаанд хамрагдсан оюутнуудын нийт эх үүсвэрийн 2.72%-г бүрдүүлдэг ба үүний 44.8%-г газар тариалан, 52.6%-г жимс, 2.6%-г мод зарах зэргээс бүрдүүлдэг байна(Диаграмм-4).




**Диаграмм-4 . Ургамлын нөөц ашиглалтын хувилбаруудын эзлэх хувь**

Судалгаанаас харахад Хэнтий, Архангай, Хөвсгөл, Булган аймгаас суралцаж байгаа оюутнууд зуны амралтаараа жимс түүж зараад төлбөрийн тодорхой хувийг бүрдүүлэх хувь нь бусад аймгуудаас илүү өндөр, Сэлэнгэ аймгаас суралцаж буй оюутны газар тариалангаас бүрдүүлэх хувь нь илүү, Төв аймгаас суралцаж байгаа оюутны мод зарж төлбөрийн эх үүсвэрээ бүрдүүлэх хувь нь илүү байгаа нь харагдаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг хувиар авч үзвэл нийт 85 оюутнаас 31 буюу 36.5% нь гар аргаар алт олборлодог, 2 буюу 2.3% нь газрын тосны үйлдвэрт ажилладаг, 3 буюу 3.6% нь жонш олборлодог, 20 буюу 23.5% нь кофед ажилладаг, 14 буюу 16.5% нь зах дээр бараа зардаг, 15 буюу 17.6% нь дэлгүүрт ажилладаг байна. Үүнээс уул уурхай, ашигт малтмалын салбарт өөрөө хөдөлмөр эрхэлдэг оюутнууд нь судалгаанд хамрагдсан нийт оюутны зардалын 1,38%-г бүрдүүлдэг байна.

Уул уурхайн салбарт хөдөлмөр эрхэлж байгаа оюутнуудыг харъяалалаар нь авч үзвэл: Баянхонгор, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл, Дорноговь аймгуудад харъяалалтай оюутнууд энэ салбарт хөдөлмөр эрхлэх хандлага нь давуу байгаа нь харагдаж байна. Газрын тос олборлоход 2 оюутан байгаагийн Дорнод, Дорноговь аймгуудад, жонш олборлолтын 3 оюутан нь Дорноговь, Хэнтий аймгуудад харъяалагдаж байна (Диаграмм-5).



*Диаграмм-5. Уул уурхайн салбарт хөдөлмөр эрхэлдэг оюутнуудын харъяалал*

### Дүгнэлт

1. Оюутнуудын сургалтын төлбөрийн эх үүсвэр нь мал аж ахуй, хувийн бизнес, цалин дээр суурилдаг боловч 100% эдгээр эх үүсвэрээс бүрдүүлдэггүй байна. Тиймээс төлбөрийн дутуу хэсгийг уул уурхай, ан амьтан, мод, жимс зэрэг байгалийн нөөцийг шууд ашиглаж бүрдүүлдэг болох нь харагдаж байна. Судалгаанаас үзвэл Баянхонгор, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл, Дорноговь аймгуудад гар аргаар алт олборлолт бусад аймгуудаас илүү байна. Агнуурын амьтдаас чоно, тарвага, загас, шонхор шувуу, үнэг, хярс, цагаан зээр зэрэг амьтдыг илүү ихээр агнадаг байна. Баян-Өлгий, Хөвсгөл, Булган, Говьсүмбэр, Сүхбаатар, Дорнод аймаг ангийн нөөц ашиглалт бусад аймгуудтай харьцуулахад илүү байна.
2. Үндсэн 3 бүлгийн зөвхөн аль нэгнээс нь 100% сургалтын төлбөрийн эх үүсвэрээ олдог оюутнууд нь нийт оюутны 36,8%, тэр дундаа зөвхөн мал аж ахуйгаас сургалтын төлбөрийн эх үүсвэрээ бүрдүүлдэг оюутнууд 18,4%-г дангаараа эзэлж байна. Мал аж ахуй нь оюутны төлбөрийн ихэнх хэсгийг бүрдүүлж байгаа нь цаад утгаараа мөн л байгалийн нөөц бэлчээртэй холбоотой юм. Эдгээрээс дүгнэвэл оюутны төлбөрийн эх үүсвэрт байгалийн нөөц (**үүнд бэлчээр, ан амьтан, жимс, мод, алт, газар тариалан, газрын тос**) 54.4%-ийг эзэлж байна.